

Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн 2019.02.12-ны өдрийн 02 дугаар хуралдааны шийдвэрээс:

2.1. “Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдааны 2018 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилт, “Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанаар 2019 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө”-ний төслийг тус тус хэлэлцээд “Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдааны 2018 оны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн дүнг 93,0 хувийн хэрэгжилттэйгээр батлав. “Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлийн хуралдаанаар 2019 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө”-ний төслийг ОБЕГ-ын даргын тушаалаар батлуулахаар шийдвэрлэв.

2.2. “Гамшгийн орон зайн мэдээллийн системийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын төслийг хэлэлцээд дахин боловсруулж, нягтлан шалгаад дараагийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтов.

2.3. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг хэлэлцээд 84,0 хувийн хэрэгжилттэй батлав.

2.4. Онцгой байдлын ерөнхий газарт гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг хэлэлцээд “Монгол Улсын Онцгой байдлын албаны хот доторх эрэн хайх, аврах ажиллагааны чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн 2018 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 100 хувь, “Зуд болон ой, хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн 2018 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 94,8 хувь, “Монгол Улсын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 2018 оны жилийн эцсийн хэрэгжилтийг 60,0 хувьтайгаар тус тус батлав.

2.5. “Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын нийгмийн баталгааг хангах дунд хугацааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтэд 2018 оны жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн дүнг хэлэлцээд 90,0 хувийн биелэлттэй батлав.